



БОЛОВСРОЛЫН САЙД
Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.05.04 № 24

Дунд болон ахлах ангийн суралцагчдын
өдрийн хоолны үйлчилгээний талаар

Ерөнхий боловсрол эзэмших хугацаа нь хүүхдийн оюуны болон бие бялдрын өсөлтийн хамгийн чухал үе тул эрүүл, аюулгүй хоол хүнсээр хангах, зөв зохистой хооллох мэдлэг, дадал төлөвшүүлэх нь насан туршийнх нь эрүүл мэндийг тодорхойлогч гол хүчин зүйлсийн нэг болдог. Түүнчлэн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг нийгмийн халамжийн бодлогын салшгүй хэсэг, ирээдүйн эрүүл иргэн бий болгох арга зам, хүүхэд хамгааллын илрэл суралцах таатай орчин бүрдүүлэлтийн салшгүй нэг хэсэг гэж үздэг.

“Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Энэ хууль нь ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа болон дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй /цаашид “сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэх/ холбоотой харилцаанд үйлчилнэ.” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад “суралцагчийг тэгш хамруулах” зарчмыг сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд баримтлахаар тус тус хуульчилсан.

Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 53 дугаар тогтоолыг баталсан бөгөөд тус тогтоолд Монгол Улсын Их Хурлын 2022 оны 70 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж, “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 5.1.1-д заасны дагуу өдрийн хоолны үйлчилгээнд бага ангийн суралцагчдыг 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн, дунд болон ахлах ангийн суралцагчдыг зохих бэлтгэл хангасны үндсэн дээр үе шаттайгаар тус тус хамруулах” гэж заасан.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн суралцагчдын өдрийн хоолны үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийн биелэлтийг хэрхэн зохион байгуулж, ямар үр дүнд хүрсэн талаар дараах асуулгыг Танд тавьж байна.

1.Дунд болон ахлах ангийн суралцагчдыг өдрийн хоолны үйлчилгээнд хамруулах бэлтгэл хангалтын байдал, өнөөдрийн байдлаар хүрсэн үр дүн, тус хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хүний нөөц, төсөв болон төсөвт үзүүлэх ачааллыг хэрхэн зохион байгуулах талаарх мэдээлэл;

2026000068

2.Өдрийн хоолны үйлчилгээнд бага ангийн суралцагчдыг 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн хамруулснаар бий болсон зэрэг болон сөрөг бодит үр дагавар, үр нөлөөний талаарх мэдээлэл. Тухайлбал, бие бялдрын өсөлт хөгжлийн байдал, сургууль завсардалт, хичээлийн ирц, сургуулийн орчинд хүнсний чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангаагүй хоол хүнснээс шалтгаалсан, болон суралцагчийн өдрийн хоолны үйлчилгээтэй холбоотой хордлого зэрэг.

3.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад заасан тэгш хамруулах зарчмыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэхээр хэрэгжүүлсэн, цаашид авах зайлшгүй шаардлагатай арга хэмжээний хувилбарын талаарх мэдээлэл зэрэг болно.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацааны дотор ирүүлэхийг хүсье.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлд заасны дагуу холбогдох Байнгын хороогоор хэлэлцүүлэх бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжвэл асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Т.МӨНХСАЙХАН

9928000000